



ТӨВ АЙМГИЙН
БАЯНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Баяндэлгэр уул

Сумын газрын үнэлгээ, төлбөрийн бүсийн
хил зааг, төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

“Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.2. /д/, 25 дугаар зүйлийн 25.1, “Захиргааны Ерөнхий хууль”-ийн 64 дүгээр зүйлийн 64.1, “Газрын төлбөрийн тухай хууль”-ийн 6 дугаар зүйлийн 6.3, Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн эдийн засгийн давуу тал, байгаль экологийн онцлог шинж чанар, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хэтийн хөгжлийг харгалзан Газрын үнэлгээ, төлбөрийн бүсчлэл тус бүрээр тогтоосон хөдөө аж ахуйн газрын төлбөрийн хувь хэмжээг нэгдүгээр хавсралтаар, хот тосгон бусад суурины газрын төлбөрийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар, зам шугам сүлжээний газрын төлбөрийн хэмжээг гуравдугаар хавсралтаар, “Газрын үнэлгээ, төлбөрийн бүсийн хил заагийг харуулсан зураг”-ийг дөрөвдүгээр хавсралтаар, Газрын үнэлгээ, төлбөрийн бүсийн хил заагийн солбилцолыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумын Засаг дарга /З.Дэлгэрцэцэг/-д ДААЛГАХ нь:

2.1. Газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоосон талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад тайлбарлан таниулж, газар эзэмшигч, ашиглагчдын газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн хийж, хугацаанд нь хураан барагдуулж төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах

2.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад байгаагаас бусад төрийн өмчийн газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын арга хэмжээнд шаардагдах зардлыг зохих журмын дагуу жил бүрийн төсөвт тусган батлуулж, зарцуулах

3. Тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Ё.Батхуяг/-д даалгасугай.

D 2021 Togtool

• 21 402

4. Тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.


5. Тогтоолын хэрэгжилтэнд нь хяналт тавихыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭНХТҮВШИН

Төв аймгийн Баяндэлгэр сумын иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04 дугаар
сарын 30 - ний өдрийн дугаар тогтоолын
1 дугаар хавсралт



Төв аймгийн Баяндэлгэр сумын хөдөө аж ахуйн газрын төлбөрийн хэмжээ

Үндсэн ангилал	Код	Ангиллын түвшин	Суурь үнэ	Итгэлцүүрийн хэмжээ	Газрын төлбөрийн хэмжээ га /төгрөг/	тайлбар
Хөдөө аж ахуйн газар	1	Бэлчээр	5859000	0,03	17577	Х-8
		Бэлчээр	9072000	0,03	27216	Х-9
		Хадлан	1946000	0,01	19460	Х-8
		Хадлан	3024000	0,01	30240	Х-9
		Тариалан	3024000	0,03	90720	Х-8
		Тариалан	4704000	0,03	141120	Х-9
		ХАА-н барилга, байгууламжийн газар, ХАА-н үйлдвэрлэл	30000000	1	150000	Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу 2 дахин багасгаж тооцно /7.2.3. Хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газрын төлбөрийг тухайн нутаг дахь хамгийн ойр орших хот, тосгон, бусад суурины газрын төлбөрийн хэмжээг хоёр дахин багасгаж тооцно./

Төв аймгийн Баяндэлгэр сумын иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04 дугаар
сарын 30 -ний өдрийн дугаар тогтоолын
2 дугаар хавсралт

Хот тосгон бусад суурины газар

Үндсэн ангилал	Код	Ангиллын түвшин	Суурь үнэ	Итгэлцүүрийн хэмжээ	Газрын төлбөрийн хэмжээ га /төгрөг/	Тайлбар
Хот тосгон бусад суурины газар	2	Гэр бүлийн хэрэгцээний газар	14000000	0,3	42000	Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт заасны дагуу 90% чөлөөлж тооцно / 2 Монгол Улсын иргэнийг ахуйн зориулалтаар эзэмшиж, ашиглаж буй 0,07 га хүртэлх хэмжээний газрынх нь төлбөрийн 90 хувиар;/
		Худалдаа бүх төрлийн үйлчилгээний газар	20 000 000	1	200000	Хэрвээ тухайн байршил нь тусгай хамгаалалттай газарт хамаарч байгаа тохиолдолд "Газрын төлбөрийн тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу 3 дахин өсгөж тооцно /6. Тусгай хамгаалалттай газар нутагт зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг уг газар нь хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойрог, хот тосгон, бусад суурины газрын үнэлгээний зэрэглэлийн алинд хамаарч байгааг харгалзан гурав дахин өсгөж тооцно./
		ХАА-гаас бусад үйлдвэрлэл	16000000	0,3	42000	/"ХАА-гаас бусад үйлдвэрлэл" гэдэгт хүнд, хөнгөн үйлдвэрлэл, уул уурхай явуулахад зориулсан газар хамаарна/
		ХАА-гаас бусад үйлдвэрлэл	16000000	0,3	42000	/"ХАА-гаас бусад үйлдвэрлэл" гэдэгт хүнд, хөнгөн үйлдвэрлэл, уул уурхай явуулахад зориулсан газар хамаарна/


Төв аймгийн Баяндэлгэр сумын иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04 дугаар
сарын 30 - ний өдрийн дугаар тогтоолын
3 дугаар хавсралт




Зам шугам сүлжээний газар

Үндсэн ангилал	Код	Ангиллын түвшин	Суурь үнэ	Итгэлцүүрийн хэмжээ	Газрын төлбөрийн хэмжээ га /төгрөг/	тайлбар
Зам, шугам сүлжээний газар	3	Авто замын газар	5000	км	5000	Улсын чанартай авто зам
			2500	км	2500	Орон нутгийн чанартай зам
			2500	км	2500	Аж ахуй нэгж байгууллагын дотоодын зам
			7500	км	7500	Олон улсын чанартай авто зам
	Шугам, сүлжээний газар	7500	км	7500	холбоо, мэдээлэл дамжуулах хүлээн авах станц, шугам	
		7500	км	7500	Эрчим хүч, дамжуулах шугам, станц	
		7500	км	7500	Газар дээрх нефть, хий дамжуулах хоолой	
		7500	км	7500	Дулаан, цэвэр, бохир усны шугам	
	Төмөр замын газар	7500	км	7500	Төмөр замын зурвас газар	

Төв аймгийн Баяндэлгэр сумын иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны
04 дугаар сарын 06 ний өдрийн 01
дугаар тогтоолын 4 дугаар хавсралт



Төв аймгийн Баяндэлгэр сумын төв суурьшлийн
бүсийн зураг



Кординат

1. X:280121,206 Y:5288533,746
2. X:280328,756 Y:5289359,081
3. X:281787,227 Y:5288956,744
4. X:282575,136 Y:5292359,843
5. X:286028,527 Y:5290817,552
6. X:285190,325 Y:5287800,026
7. X:286950,549 Y:5286727,128
8. X:286715,853 Y:5286006,274
9. X:289909,655 Y:5288118,543
10. X:279859,363 Y:5288101,779